



ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ ЗАЛУУЧУУД - ОЛОН УЛСЫН ЗАЛУУЧУУДЫН ӨДӨРТ

Дэлхий дахинаа Олон улсын Залуучуудын өдөр 8 дугаар сарын 12-ныг 2000 оноос хойш тэмдэглэж байна. Энэ жил Залуучуудын өдрийг “2030 онд хүртэлх зам: Ядуурлыг бууруулж, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжигч” уриан дор тэмдэглэж байна.

2016 оны 6 дугаар сард Монгол улсад нийслэл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын (ИТХ) сонгууль болсон. Олон улсын Залуучуудын өдөрт зориулан аймгийн ИТХ-д сонгогдсон зарим залуу төлөөлөгчтэй залуучуудын оролцоо, сонгууль хугацаандаа хийхээр төлөвлөж буй ажил, Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг сэдвээр ярилцав.



ТӨВ АЙМАГ

“Намайг Сүхбаатарын Баярмаа гэдэг. 31 настай. Банкны эдийн засагч мэргэжилтэй. 2008-2016 онд сумын ИТХ-д төлөөлөгч, Тэргүүлэгч, 2008-2012 онд сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байсан. 2016 онд Төв аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдсон.

Анх 23 настайдаа ИТХ-д нэр дэвшиж байхад хамгийн залуу нь байлаа. Тэр үед залуучууд маш ховор ИТХ-д байсан. Миний хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагад залуучуудыг олноор оруулах хүсэл эрмэлзэлтэй явдаг. Яагаад гэвэл залуучууд гэдэг маш их эрч хүчтэй, шинэ санал санаачлага гаргах тал дээр байнга өөрсдийгөө хөгжүүлж байдаг хүмүүс юм.

Орон нутгаа хөгжүүлэх талаар маш олон зүйлийг төлөвлөж бодож явдаг. Манай аймаг олон сумтай, дэд бүтэц сайн хөгжсөн ч гэсэн ажилгүйдэл, ядуурал аль ч суманд очсон байсаар л байдаг. Залуучууд энэ асуудалд өөрсдийн дуу хоолойг хүргэж байх нь маш чухал. Иймд өөрсдийгөө гололгүй нутаг орноо хөгжүүлэх үйл хэрэгт зорилготой, зоригтой оролцох хэрэгтэй гэж боддог. Миний хувьд хамгийн түрүүнд хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх ажлыг хийнэ гэж бодож байгаа. Энэ асуудал энгийн боловч хугацаа шаардсан зүйл л дээ”.



БАЯНХОНГОР АЙМАГ

“Намайг Жамбалдоржийн Пүрэвсүрэн гэдэг. 31 настай. Өмнө нь Баян-Овоо сумын ИТХ-ын дарга, сумын засаг даргаар ажиллаж байгаад 2016 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон. Татварын эдийн засагч мэргэжилтэй.

Өмнөх ИТХ-уудтай харьцуулахад энэ удаагийн ИТХ-д залуучуудын төлөөлөл нэлээд их сонгогдсон. Залуу төлөөлөгчийн хувьд асуудал бүрт хариуцлагатай хандаж, хуулийн хүрээнд залуу хүний хүний сэтгэлгээ, эрч хүч, шийдэл зэргийг шийдвэрт оновчтой тусгаж байгаасай л гэж бодож байна”.

ОРХОН АЙМАГ

Орхон аймгийн ИТХ-ын төлөөлөгч Гомбонасангийн Эрдэнэбат, 30 настай, инженер, эдийн засагч нягтлан бодогч.

“Өмнө нь ганц хоёр залуучууд ИТХ-д сонгогддог байсан ч яг шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, залуучуудынхаа санаа бодол, хүсэл сонирхлыг илэрхийлж ажиллаж байсан уу гэвэл хангалттай биш санагддаг. Энэ удаад Орхон аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн дүнгээр залуучуудын төлөөлөл боломжийн хэмжээнд сонгогдсон. Гэхдээ залуучуудын дуу хоолой үгүйлэгдэж байсныг энд хэлмээр байна. Одоо залуучууд бид үгээр биш үйлдлээр харуулах цаг нь болсон гэж бодож байна.

Мэдээж иргэд сонгогчдынхоо итгэлийг даана гэж сонгогдсон залуу хүний хувьд өөрөөсөө шалтгаалах бүхий л зүйлээ дайчлан ажиллах бодолтой явдаг. ИТХ-ын хуралдаанаас гарч байгаа шийдвэрт иргэд, олон нийтийн санаа бодол, хүсэлтийг аль болох ямар нэгэн байдлаар тусгахыг хичээж ажиллана. Бүгдээрэй хэлэлцвэл буруу шийдвэр гаргах нь бага болов уу гэж боддог. Ажилгүй байгаа залуучуудыг мэргэжилтэй болгох цаашлаад ажил орлоготой болгох тал дээр түлхүү анхаарч ажиллана.

Тогтвортой хөгжлийн зорилтууд бол НҮБ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтыг илүү хөгжүүлж, шинэчилсэн үргэлжлэл нь гэж ойлгож байгаа. Дэлхийн 193 орны төлөөлөл харилцан хүлээн зөвшөөрч хүн төрөлхтний өмнө тулгамдаж байгаа хоорондоо харилцан хамааралтай асуудлуудыг системтэйгээр шийдвэрлэхээр Дэлхийг шинэчлэх нь: “Тогтвортой хөгжил-2030” тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлж баталсан. Энэ хөтөлбөрийг боловсруулахдаа дэлхийн 8 сая иргэний санал хүсэлтэд тулгуурласан төдийгүй Монгол Улсын хувьд 5000 иргэн саналаа өгсөн юм байна лээ. Энэ нь хэнийг ч орхигдуулалгүй, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, эх дэлхийгээ хамгаалж, хүн төрөлхтнийг тайван амгалан, баян чинээлэг, эрх тэгш амьдрах боломжоор хангах даян дэлхийн уриалга юм шүү дээ”





БАЯНХОНГОР АЙМАГ

“Намайг Батсүрэнгийн Нацагдорж гэдэг. 31 настай, шүдний эмч. 2012 онд сумын ИТХ-д ажилласан, 2016 онд Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон.

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд залуучуудын төлөөлөл, оролцоо бага гэж үзэж байна. Нутаг орноо хөгжүүлэхэд залуучуудын оролцоо маш хэрэгтэй гэж боддог. Ялангуяа ИТХ-аас хүн амыг ажлын байраар хангах зорилтыг тавин ажиллах хэрэгтэй. Залуучууд бид аливаа ажлыг голохгүй хийх хэрэгтэй байна. Миний хувьд хүн амыг эрүүл байлгах ажилд анхаарал хандуулах болно.

Тогтвортой хөгжлийн зорилт нь НҮБ-ийн 193 орны нэгдсэн шийдвэрээр 17 зорилго, 169 зорилтыг Мянганы хөгжлийн зорилгын үнэлгээнд суурилан гаргасан. Ядуурлыг бууруулах, устгах, эх дэлхийгээ хамгаалах, байгаль орчноо хамгаалах, хүний тайван амгалан амьдрах эрхийг хангах гэх мэт зорилтуудыг дэвшүүлсэн. Миний хувьд хүн амын эрүүл мэндийг дэмжих зорилтыг дэмжин ажиллах болно”.

УВС АЙМАГ

“Намайг Тулгын Амарзаяа гэдэг. 33 настай, дотрын эмч. 2016 онд Увс аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдсон.

ИТХ-д залуучуудын төлөөлөл харьцангуй бага байсан, харин 2016 оны сонгуульд олон залуучууд төлөөлөгч болж орж ирсэн нь бахархуштай, гэхдээ бас хариуцлагатай байхыг шаардаж байна гэж үзэж байна. Орон нутгаа хөгжүүлэхэд залуучуудын оролцоо нөлөө их, бид ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралыг дээшлүүлэхийн тулд

- малын түүхий эд, ноос ноолуур, мах, сүү сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, зээлд нийлүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих,
- Дотоодын үйлдвэрлэлээ дэмжиж, брэнд болгон, зах зээлд нийлүүлэх, чанарыг сайжруулан экспортлох,
- сум орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нүүдлийн соёл иргэншлийг таниулах сурталчилах, аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- эрүүл мэндийн салбарыг орчин үеийн техник технологиор бүрэн хангаж, эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад мэргэжил дээшлүүлснээр дотооддоо эмчилгээ, оношлогоог дэлхийн түвшинд хийдэг болох, ингэснээр гадагшаа үрсах мөнгөний үрсгалыг зогсоох хэрэгтэй гэж бодож байна”.



ТӨВ АЙМАГ

“Намайг Нямдоржийн Дугар гэдэг. 31 настай. Компьютерийн программ хангамжийн мэргэжилтэй, АНУ-д компьютерийн шинжлэх ухааны магистрийн зэрэг хамгаалсан, мөн ШУТИС-т докторантурт суралцаж байна. 2016 онд Төв аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон.

2016 оны орон нутгийн ИТХ-ын сонгуулийн үр дүнг харахад залуучуудын төлөөлөл хангалттай орж ирсэн. Би сурсан мэдсэнээ эх орондоо зориулах гэж зорин ирсэн олон залуучуудын төлөөлөл.

Манай Төв аймгийн хувьд хэд хэдэн залуу төлөөлөгч нар бий. Бид улс орны ирээдүйн хөгжлийн тулгуур болсон залуучууд руугаа чиглэсэн

бодлого барьж ажиллах тал дээр нэгдэж байгаа. Төв аймгийн иргэдийн диилэнх нь хүүхэд залуучууд. Тиймээс бид Төв аймгийнхаа хүүхэд залуучуудын хөгжлийн төлөөх бодлого, залуучуудын байгууллагыг дэмжин ажиллах нь чухал гэж бодож байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах, залуу гэр бүлүүдэд хөнгөлттэй зээл олгох, залуучуудын боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах төлөвлөгөөтэй байна. Өөрсдийнхөө юу чаддаг болгоноороо нутгийнхаа хөгжлийн төлөө ажиллаж, хөдөлмөрлөө, бүтээе, нэгдэе гэж уриалмаар байна”.


ӨМНӨГОВЬ АЙМАГ

“Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч Элдэв-очирын Өлзийжаргал, эрх зүйч.



Сүүлийн 3 удаагийн орон нутгийн сонгуулийн үр дүнг ажиглахад залуучуудын оролцоо бага байсан гэж үзэж байна. Орон нутгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах төлөвлөгөөг олон жилийн судалгаа, статистик мэдээ мэдээлэлд тулгуурлан дунд болон урт хугацаанд гаргах ёстой. Орон нутгийн түвшинд өөрийн боломж бололцоогоор бие даасан байдлаар бодлогын баримт бичиг боловсруулж, үе дамжин тодотгож явах ёстой гэж боддог”.

“МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2016



Ирээдүйн сайн сайхны төлөө: Монгол Улсын хөгжилд залуучуудын оролцоо



<http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/presscenter/pressreleases/2016/06/14/faaf/>